



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



ҮНИЙН ТҮВШИН





Энэхүү гарын авлагыг “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд боловсруулав.

Монголбанкны зөвшөөрөлгүйгээр товхимолыг цахим болон хэвлэмэл байдлаар, бүтнээр, эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх бусад хэлбэрээр түгээхийг хориглоно.

© Монголбанк

Үнэгүй тараагдана.



ӨМНӨХ ҮГ

“Иргэн баян бол улс баян” гэдэг. Энэ нь иргэн бүр эрх, үүргээ ухамсарлан, өөрийн амьдрал ахуйд эзэн болж чадвал улс орны хөгжил өөдрөг сайн байхыг өгүүлж буй хэрэг билээ. Нөгөө талаас, аливаа улсын хөгжлийн эрхэм зорилго бол ард иргэдийнхээ сайн сайхан аж байдлыг дээшлүүлэх явдал байдаг. Энэ зорилгод хүрэхэд улс орон эдийн засгийн хувьд чадамжтай, хувь хүмүүс ашиг орлого, хөрөнгө мөнгө сайтай байх нь их чухал. Төр засаг дангаараа энэ зорилгыг биелүүлэхэд хүч хөрөнгө дутах тул ард иргэдийн үүрэг, хувь нэмэр, идэвх санаачилга, оролцоо хэрэгтэй юм.


Хүний хязгааргүй хэрэгцээг хангах нөөц хүрэлцдэггүй нь хүн төрөлхтний бүх түүхэн дэх гачлан байлаа. Гэхдээ бид хязгаарлагдмал нөөцөөр хязгааргүй хэрэгцээгээ хангахын төлөө тэмүүлдэг. Тэгвэл хэрэгцээгээ сайтар хангахын тулд хязгаарлагдмал нөөц, хөрөнгө мөнгийг зөв зарцуулахад хувь хүний санхүүгийн ухаалаг төлөвлөлт томоохон байр суурь эзэлнэ. Хувь хүн та өөрийн бүхий л талын нөөц бололцоог дайчлах, нийгэм, эдийн засаг, санхүүгийн үйлчилгээний талаарх өөрт хэрэгтэй мэдээллийг олж авах, олж авсан үнэн зөв мэдээллээ шийдвэр гаргах, сонголт хийхдээ оновчтой хэрэглэх, зөв мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд энэ сурах бичиг Танд тус болох нь дамжиггүй.

МОНГОЛБАНК
ОЛОН НИЙТИЙН БОЛОВСРОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ



ТАЙЛБАР

Сэдвийг амьдралд ойртуулах, ойлгомжтой болгох үүднээс Монголын мянга, мянган өрхийг төлөөлсөн Гарьдын гэр бүлийн гишүүдийн зохиомол дүрийг жишээнд ашиглан айл өрх бүрт тулгардаг санхүүгийн асуудлыг зөв шийдвэрлэхэд туслахыг зорилоо. Та бүхэнд Гарьдын өрхийн гишүүдийг товч танилцуулъя.





1. Үнийн өсөлт ба амьжиргааны өртгийн уялдаа холбоо

Хүн аж амьдралаа зохицуулахдаа өдөр тутам мөнгөтэй холбоотой шийдвэр гаргадаг. Үүнийг санхүүгийн шийдвэр гэж нэрлэнэ. Бид санхүүгийн оновчтой шийдвэр гаргаснаар мөнгөө зөв зарцуулж, хуримтлал үүсгэн, ая таатай амьдрах боломж бүрдүүлж чадна. Гэтэл биднээс хамаарахгүйгээр өөрчлөгдөж, эргээд бидний амьдралд нөлөөлдөг хүчин зүйлс байна. Жишээ нь: Ажил эрхлэлт, улсын эдийн засгийн байдал, зээлийн хүүний түвшин, мөнгөний нийлүүлэлт гэх мэт. Эдгээрээс бидний өдөр тутмын амьдрал, амьжиргаанд хамгийн их нөлөө үзүүлдэг хүчин зүйлийн нэг нь инфляци юм.

Инфляци: Үнийн ерөнхий түвшний өсөлтийг харуулсан үзүүлэлт юм.

Инфляцийг бид хялбараар бараа, үйлчилгээний үнийн өсөлт, мөнгөний худалдан авах чадварын бууралт гэж ойлгож болно.

Зураг 1. Инфляци



Бараа, үйлчилгээний
үнийн өсөлт



Мөнгөний худалдан авах
чадварын бууралт






Хэрэв инфляцигүй байвал юмны үнэ өөрчлөгдөхгүй. Гэтэл инфляци өсөхөд мөнгөний худалдан авах чадвар буурч, барааны үнэ өсдөг. Жишээ нь: “Атар” талхны үнэ 1990 онд 1.2 төгрөг байсан бол 2018 онд 1320 төгрөг болж 1100 дахин өссөн байхад, мөнгөний худалдан авах чадвар харин урвуугаар 1100 дахин буурчээ.



Зураг 2. Талхны үнийн өсөлт



Гэхдээ инфляцийг зөвхөн нэг барааны үнийн өсөлтөөр биш нийт бараа, үйлчилгээний үнийн дундаж түвшний өсөлтөөр хэмжинэ. Бүх бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг улсын хэмжээгээр нэг бүрчлэн хэмжих боломжгүй. Иймээс хүн амын өргөн хэрэглээний гол нэрийн бараа, үйлчилгээг сонгон авч, тэдгээрийн үнийн дундаж өөрчлөлтийг тооцдог. Сонгон авсан эдгээр бараа, үйлчилгээг ХЭРЭГЛЭЭНИЙ САГСНЫ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ гэнэ.

Хэрэглээний сагсны бараа, үйлчилгээ: Айл өрхийн бүх хэрэглээг төлөөлж чадах өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн багцыг хэлнэ. Хэрэглээний сагсны бүтцийг айл өрхүүдийн хэрэглээ, түүний хэв маягт судалгаа хийсний үндсэн дээр тодорхойлдог. **МУ-ын хэрэглээний сагс нийт 12 бүлгийн 373 бараа, үйлчилгээнээс бүрдэж байна.**



ХЭРЭГЛЭЭНИЙ САГС


Инфляцийг
Үндэсний
статистикийн
хороо тооцно.



Дээрх нэр төрлийн бараа, үйлчилгээний үнийн дундаж өсөлтөөр инфляцийг хэмжинэ. Хэрэв зах зээл дээр бараа, үйлчилгээний үнэ өсөөд байвал иргэдийн амьдралд муугаар нөлөөлдөг.


Үүнийг нөгөө талаас авч үзвэл, инфляци өсөхөд айл өрхийн олж байгаа орлого буюу мөнгөнийх нь худалдан авах чадвар буурна. Жишээ нь: Инфляци 25 хувиар өсөхөд 1000 төгрөгийн худалдан авах чадвар 25 хувиар буурна. Үүнийг талхаар зүйрлэн харуулъя

Зураг 3. Нэг мянган төгрөгийн худалдан авах чадвар



2016 он

Талхны 4-ний 1
нь хаачихав ?



2018 он

2. Инфляци хадгаламжинд нөлөөлөх нь

Инфляци мөн иргэдийн хуримтлал, хадгаламжид сөргөөр нөлөөлнө. Инфляцийн түвшний өсөлт хадгаламжийн хүүний өсөлтөөс давсан тохиолдолд иргэдийн хадгаламж үнэгүйдэж эхэлдэг. Хадгаламж төдийгүй бусдад бэлэн мөнгө зээлдүүлсэн тохиолдолд мөн адил үр дагаврыг авчирна. Энэ талаар иргэн Гарьдын хадгаламж дээр жишээ авч үзье.



Гарьд 45 настай.

Түүний гурав дахь хүү Тэнгис 17 настай. Дараа жил дээд сургуульд элсэн орох зорилготой бөгөөд түүний орохыг хүссэн дээд сургуулийн жилийн сургалтын төлбөр 1000000 (нэг сая) төгрөг байна.

Иргэн Гарьд хүүгийнхээ сургалтын төлбөрт зориулж 1000000 төгрөгийг нэг жилийн хугацаатай, жилийн 15 хувийн хүүтэй хадгаламжид хийв.

ГЭТЭЛ...

Жилийн дараа инфляцийн түвшин 20 хувиар өссөн тул Тэнгисийн элсэн орохоор төлөвлөж байсан дээд сургууль нэг жилийн сургалтын төлбөрөө 20 хувиар нэмэгдүүжээ.

Үүний үр дагавар юу болох вэ?

Гарьдын хадгаламж жилийн дараа хүүний хамт 1150000 төгрөг болсон бол Тэнгисийн орохоор зорьсон дээд сургуулийн сургалтын төлбөр 1200000 төгрөг болж нэмэгджээ.

Жилийн өмнө нэг жилийн сургалтын төлбөрийг төлөхөд хүрэлцэхүйц мөнгө Гарьдын хадгаламжид байсан. Жилийн дараа инфляцийн улмаас түүний хадгаламж дахь мөнгөний үнэ цэнэ буурч, сургалтын төлбөр төлж хүрэлцэхгүй болсон байна.



ТАНЫ МЭДЛЭГТ

Манай улсад 1992 онд инфляцийн түвшин 325.5 %-д хүрч байжээ.



3. Инфляци байх шаардлагатай юу?

Үнэ буурах нь бизнес эрхлэгчдэд сөрөг нөлөөтэй байдаг, учир нь ирээдүйн зарах бүтээгдэхүүнийх нь үнэ нэмэгдэхгүй. Энэ нь ажиллагчдынхаа цалин өсөхгүй, эсвэл урамшуулал олгохгүй гэсэн үг юм. Ингэснээр ажиллагчид хөдөлмөрлөх сонирхолгүй болох, бүтээмж, үйлдвэрлэл буурахад нөлөөлнө.

Инфляци өндөр байх нь иргэдийн амьжиргааны түвшин буурах, санхүүгийн систем тогтворгүй болох, эдийн засаг тогтворгүй болох эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Үнэ урт хугацаанд нам тогтвортой хэмжээнд өсөх нь хамгийн зохистой.

4. Үнэ тогтвортой байхын ач холбогдол

Инфляци нь эдийн засгийн өсөлт, ядуурал гэх мэт шиг үргэлж олны анхаарлын төвд байдаг сэдэв биш бөгөөд үнэ тогтвортой үед “мартагддаг” гэж хэлж болохоор үзүүлэлт. Харин үнэ хурдтай өөрчлөгдөж эхэлсэн цагт л үнийн тогтвортой байдал ямар чухал болохыг ухаарах нь түгээмэл.

Үнэ тогтвортой байна гэдэг нь нийт ард иргэдэд ашигтай зүйл бөгөөд эдийн засаг тогтвортой, үр ашигтай ажиллах суурь хөрс болдог. Учир нь бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өөрчлөлт бол худалдан авч буй хэрэглэгчид, мөнгөө хадгалуулж буй хадгаламж эзэмшигчид, эсвэл хөрөнгө оруулалт хийж буй бизнесийн байгууллагууд гээд хэн бүхэнд шууд нөлөөтэй. Харин үнэ тогтворгүй үед иргэдийн бодит орлого буурах, ядуурал нэмэгдэх, нийгэмд тэгш бус байдал даамжрах г.м. олон сөрөг үр дагавар бий болдог.

ҮНЭ ТОГТВОРГУЙ ҮЕД ЮУ ҮҮСЭХ ВЭ?

- Үнийн өсөлт 231 сая хувьд хүрч, 100 триллионы дэвсгэрт гүйлгээнд гаргахад хүрч байсан Зимбабве улсын 2008 оны үйл явдал гипер инфляци иргэдийн худалдан авах чадварт хэрхэн нөлөөлж, эдийн засгийг сүйрүүлж болохыг харуулсан.
- Мөнгөн хуримтлалыг богино хугацаанд үнэ цэнэгүй цаас болгон хувиргах хурдтай үнийн өсөлт нь банк санхүүгийн системийг хэрхэн тогтворгүй болгодгийг 2016 оны байдлаар 40% болон 800%-ийн инфляцитай байсан Аргентин, Венесуел улсын жишээ харуулж байна.
- Инфляци хасах утгатай буюу бүтээгдэхүүний үнэ өсөх биш харин буурч, “Дефляци”-тай байх үед компаниуд зардлаа бууруулахын тулд хөрөнгө оруулалтаа танах, ажиллах хүчээ цомхотгох замаар эдийн засаг агшдаг болохыг Японы сүүлийн 30 жилийн түүхээс харж болно.




Үнэ тогтворгүй, савлагаатай байхын зовлонг Монголчууд ч амсаж туулсан бөгөөд 90-ээд оны эхэнд инфляци 300% давж, жилийн дотор үнэ 3 дахин өсөхөд иргэдийн хэрэглээ, худалдан авах чадвар, хэтэвч дэх мөнгөнд ихээхэн халгаатай дарамт учирч байсан билээ.

“Хүн нэг өглөө босоод л
санхүүгийн мэдлэгтэй болдоггүй”

Шон мэнди
(Дэлхийн банкны зөвлөх)











ТӨСӨВЧИН
Аппликэйшн



Энэхүү аппликэйшн нь өөртөө хуримтлал тооцоологч,
хадгалагч, зээл тооцоологч, ипотек, төсөвлөгч зэрэг
тооцоолууруудыг багтаасан.

www.sankhuuginbolovsrol.mn



-  /Mongolbank.mn
-  /Санхүүгийн боловсрол
-  @mongolbank_mn
-  www.mongolbank.mn
-  /Mongolbankmn
-  info@mongolbank.mn
-  11 310081